



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/01

Сүмбэр сум

Б.Түшигбаярыг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 49 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 1, 2020 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 151 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн А/294 дүгээр тушаал, Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/01 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянзулын Түшигбаярыг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс тус байгууллагын захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд түр томилсугай.

2. Баянзулын Түшигбаярыг албан тушаалын үндсэн цалинг Т3-9 зэрэглэл буюу 1'283'000 (Нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөг, орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар, орон нутгийн санхүүжилтээр олгох орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус албан тушаалын үндсэн цалингаас тооцож, хоол, унааны үнийн хөнгөлөлтийг зохих журмын дагуу бодож олгохыг ахлах нягтлан бодогч (А.Аасүрэн)-д зөвшөөрсүгэй.



Б.БОЛД-ЭРДЭНЭ